

ТӨСӨЛ

# Айвенхоу Майнз Монголиа Инк ХХК-ийн Хувь Нийлүүлэгчдийн Гэрээ

Эрдэнэс МГЛ Төрийн өмчит ХХК

ба

Айвенхоу Оюу Толгой Лимитед (Британийн Виржинийн  
аралд бүртгэлтэй) компани

ба

Айвенхоу Майнз Монголиа Инк ХХК

# Оюу Толгой Төслийн Хувь Нийлүүлэгчдийн Гэрээ

---

Огноо

2007

Талууд

1. **Эрдэнэс МГЛ [Монгол Улсын Төрийн өмчит ХХК]** (цаашид ТӨК гэх) нь Монгол Улсын Компанийн хууль тогтоомжийн дагуу байгуулагдсан Компани бөгөөд Монгол Улсын \_\_\_\_\_-д байрлах.
2. **Айвенхоу Оюу Толгой Лимитед (цаашид Айвенхоу гэх)** нь Бритиш Виржин арлын хуулийн дагуу байгуулагдсан, Канад Улсын Бритиш Колумбия мужийн Ванкувер хотын Канада Плейс 999, 654 тоот хаягаар байрлах.
3. **Айвенхоу Майнз Монголиа Инк ХХК (цаашид Компани гэх)** нь Монгол Улсын хуулийн дагуу байгуулагдсан бөгөөд Монгол Улсын Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, 1-р хороо, Залуучуудын гудамж-26, Сеул бизнесийн төв, 210349 хаягаар байрлах.

Үйл  
явдлын  
тойм

Компанийн Хувь нийлүүлэгчдийн хувьд тус тусын эрх үүргээ зохицуулахын тулд ТӨК болон Айвенхоу нь энэхүү Гэрээг байгуулах хүсэлтэй байгаа болно. Энэхүү Гэрээнд гарын үсэг зурсан өдөр Монгол Улсын Засгийн газар болон Компани нь Төслийг хэрэгжүүлэх, үйл ажиллагааг явуулах нөхцлийг зохицуулах зорилготой Хөрөнгө оруулалтын гэрээ байгуулсан ба энэхүү Гэрээ нь тус Хөрөнгө оруулалтын гэрээний хавсралт болно.

**Иймд** Талууд дараах байдлаар тохиролцов.

## 1. Нэр томъёоны тодорхойлолт

---

Гэрээнд өөрөөр заагаагүй бол тус Гэрээний нэр томъёог Хавсралт 1-д заасан тодорхойлолтын дагуу ойлгоно.

## 2. Гэрээний урьдчилсан нөхцөл

---

### 2.1 Гэрээ нөхцлөөс шалтгаалах тухай

Энэхүү Гэрээ болон энэхүү Гэрээгээр Талуудын хүлээх үүрэг ( 2 дугаар зүйл ба 11 дүгээр зүйл (Баталгаа ба төлөөлөл), 10 дугаар зүйл (Хувьцаа шилжүүлэх), 16 дугаар зүйл (Маргаан шийдвэрлэх) ба 17 дүгээр зүйл (Бусад зүйл) ийн үүрэг энд хамаарахгүй) нь дараах нөхцлийг

# Оюу Толгой Төслийн Хувь Нийлүүлэгчдийн Гэрээ

---

(цаашид "Урьдчилсан нөхцөл" гэх) хангагдах хүртэл Талуудын хувьд заавал биелүүлэх шаардлага үүсгэхгүй.

- а) Гэрээний 13 дугаар зүйлд заасны дагуу Төсөлд хамаарахгүй өмч хөрөнгийг шилжүүлж дуусгах;
- б) Компанийн нэмэлт өөрчлөлт оруулсан Дүрмийг Улсын бүртгэлийн албанд бүртгүүлэх;
- в) Хөрөнгө оруулалтын гэрээг Монгол Улсын Их Хурлаас баталж, талууд гарын үсэг зурсан байх;
- г) Энэхүү Гэрээ болон Хөрөнгө оруулалтын Гэрээ нь хуулийн хүчинтэй болох тухай хуулийг УИХ-аас баталж хүчин төгөлдөр болох

## 3. Компанийн эзэмшлийн бүтэц

---

### 3.1 Засгийн газрын хувьцааг шилжүүлэх

Энэхүү Гэрээ бүрэн хүчин төгөлдөр болох өдөр Айвенхоу нь албан ёсны эзэмшигч болон өмчлөгчийн хувьд Засгийн газарт шилжих хувьцааг аливаа нэг барьцаанаас чөлөөтэйг нотлон шилжүүлэхээр, ТӨК нь Засгийн газарт шилжүүлэх уг хувьцааг хүлээн авахаар тус тус тохиров.

### 3.2 Гэрээгээр хүлээх үүрэг

Хөрөнгө оруулалтын гэрээг Монгол Улсын Засгийн газрын нэрийн өмнөөс байгуулж байгаатай холбогдуулан Айвенхоу нь Засгийн газарт шилжих хувьцааг ТӨК-т шилжүүлэхээр зөвшөөрөв.

### 3.3 Гэрээ бүрэн хүчин төгөлдөр болох өдөр талуудын хүлээх үүрэг

- (а) Айвенхоу нь Улаанбаатар хотод энэхүү Гэрээ бүрэн хүчин төгөлдөр болох өдөр Засгийн газарт шилжих хувьцааг ТӨК-т шилжүүлэх тухай баримт бичигт гарын үсэг зурж ТӨК-д хүргүүлнэ.
- (б) ТӨК нь Засгийн газарт шилжүүлэх хувьцааг хүлээн авсан тухай баримт бичигт гарын үсэг зурж Компанид хүргүүлнэ.
- (в) Компани нь ТӨК болон Айвенхоу гарын үсэг зурж ирүүлсэн шилжүүлэх баримт бичгийг хүлээн аваад:
  - (i) Засгийн газарт шилжих хувьцааг Засгийн газарт шилжүүлсэн тухай бүртгэлд тэмдэглэнэ;
  - (ii) ТӨК-д Засгийн газарт шилжсэн хувьцааны гэрчилгээг хүргүүлнэ;
  - (iii) Хувьцаа шилжүүлэх тухай гарын үсэг зурсан баримт бичгийг Улсын бүртгэлийн алба болон Гадаадын хөрөнгө оруулалт, гадаад худалдааны агентлагт бүртгүүлнэ.

# Оюу Толгой Төслийн Хувь Нийлүүлэгчдийн Гэрээ

---

- (г) Хувь нийлүүлэгч бүр энэхүү Гэрээний 4.3 дугаарт заасны дагуу ТУЗ-ийн гишүүн томилсон тухайгаа Компанид болон бусад Хувь нийлүүлэгчид бичгээр мэдэгдэнэ.

## 3.4 Гэрээ бүрэн хүчин төгөлдөр болох өдрийн эзэмшлийн хувь хэмжээ

ТӨК нь Засгийн газрын хувьцааг шилжүүлэн авсны дараа Компани дахь Хувь нийлүүлэгчдийн хувь эзэмшлийн хэмжээ дараах байдалтай байна:

- а) ТӨК–34% ба
- б) Айвенхоу – 66% тус тус болно.

## 4. Компанийн үйл ажиллагаа ба менежмент

---

### 4.1 Компанийн үйл ажиллагааны цар хүрээ

Компани нь хуулиар хориглоогүй аливаа үйл ажиллагаа явуулж болох ба тухайн үйл ажиллагаа явуулахад шаардлагатай эрх эдэлж, үүрэг хүлээнэ.

### 4.2 ТУЗ-ийн эрх

ТУЗ нь энэхүү Гэрээний 4.10(а) зүйлд заасан Хувь нийлүүлэгчдийн хурлын онцгой эрхээс бусад Компанийн үйл ажиллагаатай холбоотой бүхий л онцгой эрхийг эдэлнэ.

### 4.3 ТУЗ-ийн гишүүд:

- а) Засгийн газрын хувьцааг ТӨК-д шилжүүлснээр гэрээний 4.3(б) зүйлийн дагуу ТӨК нь ТУЗ-ийн гурван гишүүн, Айвенхоу нь ТУЗ-ийн зургаан гишүүн томилох эрхтэйг Талууд үүгээр хүлээн зөвшөөрөв.
- б) Мөн гэрээний 4.3(в) зүйлийн хүрээнд, 10% болон түүнээс дээш хувь эзэмшиж буй Хувь нийлүүлэгч өөрийн хувь эзэмшлийн хувийг 10 хуваасантай тэнцүү тооны гишүүдийг ТУЗ-д шууд томилж, чөлөөлөх эрхтэй байх бөгөөд энэхүү тооцоогоор гарах бутархай тоог тооцохгүй.
- в) Хувь нийлүүлэгчийн хувь эзэмшлийг дээрх 4.3(б) зүйлийн дагуу тодорхойлох зорилгоор тухайн Хувь нийлүүлэгч болон түүнтэй нэгдмэл сонирхолтой этгээдийн нийт эзэмшиж буй хувьцааг нийлүүлэн тооцох ба ийнхүү хувьцааг нэгтгэснээр тухайн Хувь нийлүүлэгчдийн хувьд (нэг буюу түүнээс дээш тооны Хувь нийлүүлэгчийг хамтатгана) 4.3(б) зүйлийн дагуу заасан эрх үүснэ.
- г) ТУЗ-ийн гишүүн бүр өөрийн түр эзгүйд болон өвчтэй байх хугацаанд эсвэл ТУЗ-ийн гишүүний үүргээ биелүүлж чадахгүй байх хугацаанд, түүнчлэн ямар нэг тодорхой нөхцөл байдал үүсэх хүртэл өөрийгөө орлох этгээдийг томилж болно. Уг томилолтыг бичгээр үйлдэж, тухайн томилж буй гишүүн гарын үсэг зурж, хувийг Компанид хүргүүлнэ.

# Оюу Толгой Төслийн Хувь Нийлүүлэгчдийн Гэрээ

---

## 4.4 Санал өгөх

ТУЗ-ийн гишүүн бүр саналын нэг эрхтэй байна.

## 4.5 ТУЗ-ийн томилогдсон гишүүд

Аль нэг Хувь нийлүүлэгчийн томилсон ТУЗ-ийн гишүүн нь Компанитай холбоотой эрхээ эдэлж, үүргийг хэрэгжүүлэхдээ үйл ажиллагаагаа үнэнчээр, Компанийн эрх ашигт хамгийн сайнаар нийцүүлэн явуулж байгаа нөхцөлд өөрийг нь томилсон этгээдийн ашиг сонирхол болон хүсэлтийг харгалзан үзэж болно.

## 4.6 ТУЗ-ийн хурал

- а) ТУЗ нь улиралд нэг удаа эсвэл гурван гишүүн хүсэлт тавьсан тохиолдолд түүнээс илүү удаа хуралдаж болно. (Онцгой байдал үүсэхээс бусад үед хамгийн сүүлийн хурлаас хойш 30 хоногийн хугацаанд дараагийн хурлыг хуралдуулахыг гурван гишүүн шаардах эрхгүй). ТУЗ-өөс тогтоол гаргаж өөрөөр шийдээгүй бол:
  - (i) ТУЗ-ийн бүх хурлыг Улаанбаатар хотод хийнэ.
  - (ii) ТУЗ-ийн хурал болох талаар гишүүн бүрт наад зах нь 21 хоногийн өмнө мэдэгдэл хүргүүлнэ.
- б) Хурлын тухай мэдэгдэлд тухайн хурал дээр хэлэлцэх асуудлыг аль болох дэлгэрэнгүйгээр, түүнчлэн хэлэлцүүлэгт зориулсан холбогдох материал, танилцуулга зэргийг хавсаргасан байна. ТУЗ-ийн бүх гишүүд өөрөөр тохироогүй бол ТУЗ-ийн хурал зөвхөн хэлэлцэх асуудлын жагсаалтанд дурдсан асуудлаар шийдвэр гаргана.
- в) ТУЗ-ийн гишүүн ТУЗ-ийн хуралд оролцохоор ирэх, буцах замын зардал, гишүүний үүргээ гүйцэтгэхтэй холбоотой томилолтын болон бусад бүх зардлыг тухайн гишүүнийг томилсон Хувь нийлүүлэгч хариуцна. (Харин Төсөл дээр ТУЗ-ийн хурлыг хийх тохиолдолд Компани нь ТУЗ-ийн гишүүдийн Улаанбаатараас ирэх очих аялал, хоол, байрны зардлыг хариуцна.)
- г) ТУЗ-ийн хуралд бүх гишүүдийн дийлэнх олонхи хүрэлцэн ирсэн буюу орлох этгээдээ оролцуулсан (түүний дотор Айвенхоу болон ТӨК-ийн томилсон наад зах нь тус бүр нэг гишүүн заавал ирсэн) тохиолдолд хурлын ирц бүрдэнэ. Хойшилсон хурлаас бусад үед хурлын ирц бүрдээгүй тохиолдолд ТУЗ-ийн хурлаар ямар нэг асуудал шийдэхгүй.
- д) ТУЗ-ийн хурал эхлэхээр мэдэгдэлд заасан цагаас хойш 30 минутын дотор ирц бүрдээгүй бол хурлыг хоёр өдрөөр хойшлуулна. Хойшлуулсан хурлын хэлэлцэх асуудалд өөрчлөлт оруулахгүй. Хойшлуулсан хуралд ТУЗ-ийн нийт гишүүдийн наад зах нь тавин хувь нь хүрэлцэн ирсэн бол ирц бүрдэнэ.

## 4.7 ТУЗ-ийн дарга

- а) Айвенхоу нь ТУЗ-д өөрийн томилсон гишүүдээс ТУЗ-ийн даргаар томилж болно.
- б) Хэрэв ТУЗ-ийн хурал дээр ТУЗ-ийн дарга хүрэлцэн ирээгүй бол тухайн даргыг томилсон Хувь нийлүүлэгчийн томилсон ТУЗ-ийн гишүүд өөрсдийн дундаас нэг гишүүнийг хурал удирдуулахаар хурлын даргаар сонгож болно.

# Оюу Толгой Төслийн Хувь Нийлүүлэгчдийн Гэрээ

---

- в) ТУЗ-ийн хурал дээр аливаа асуудлаар санал тэнцвэл ТУЗ-ийн даргын саналаар шийдвэрлэнэ.

## 4.8 ТУЗ-ийн шийдвэр

Компанийн ТУЗ-ийн хурал дээр хүрэлцэн ирсэн саналын эрх бүхий нийт гишүүдийн дийлэнх олонхийн шийдвэрээр ТУЗ-ийн аливаа тогтоол, шийдвэрийг батална.

## 4.9 ТУЗ-ийн дэргэдэх хороо

ТУЗ шаардлагатай гэж үзвэл тодорхой асуудал хариуцсан нэг буюу хэд хэдэн хороог байгуулж болно.

## 4.10 Хувь нийлүүлэгчдийн шийдвэр

- а) Энэхүү Гэрээний 4.2-р зүйлд заасны дагуу Компанийн үйл ажиллагаатай холбоотой бүхий л асуудлыг ТУЗ-ийн онцгой эрхийн хүрээнд шийдвэрлэх ба 4.10(а) зүйл буюу дор дурдсан асуудлыг Хувь нийлүүлэгчдийн хурлын бүрэн эрхийн хүрээнд хэлэлцэн шийдвэрлэнэ. Үүнд:
  - (i) Компанийн Дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах буюу түүний шинэчилсэн найруулгыг батлах;
  - (ii) нийлэх, нэгтгэх, хуваах буюу өөрчлөх хэлбэрээр Компанийг өөрчлөн байгуулах;
  - (iii) Компанийн өрийг хувьцаагаар солих;
  - (iv) Компанийн хэлбэрийг өөрчлөх;
  - (v) Компанийг татан буулгах болон татан буулгах комиссыг байгуулах, мөн
  - (vi) Компанийн хувьцааг хуваах буюу нэгтгэх;
  - (vii) 5(б) дугаар зүйлд зааснаас бусад Компанийн тухай хуулийн 12-р бүлэгт заасан сонирхлын зөрчилтэй хэлцлийг хэлэлцэн шийдвэрлэх.
- б) 4.10(а)-р зүйлд заасны дагуу Хувь нийлүүлэгчдийн хурлын шийдэх асуудлыг хуралд оролцож байгаа тухайн Хувь нийлүүлэгчдийн төлөөлөгчид буюу Хувь нийлүүлэгчдийн нийт саналын эрхийн дийлэнх олонхиос дээш хувийн саналаар шийдвэрлэнэ.
- в) ТӨК болон Айвенхоугаас тус бүр нэг төлөөлөгч хүрэлцэн ирснээр Хувь нийлүүлэгчдийн хурлын ирц бүрдэнэ. Хувь нийлүүлэгчдийн хурал эхлэхэд дээрх ирц бүрдээгүй бол (харин хойшлогдсон хуралд энэ нь хамаарахгүй) Хувь нийлүүлэгчдийн хурлаар аливаа асуудлыг шийдэхгүй.
- г) Хувь нийлүүлэгчдийн хурал эхлэхээр мэдэгдэлд заасан цагаас хойш 30 минутын дотор ирц бүрдээгүй бол дараа долоо хоногийн тухайн өдөр, цаг, тухайн газарт хурлыг хуралдуулахаар хойшлуулна. Хойшлуулсан хурлын хэлэлцэх асуудалд өөрчлөлт оруулахгүй. Хойшлуулсан хуралд Компанийн саналын эрхтэй нийт хувьцааны наад зах нь дөчин хувийг (40%) эзэмшдэг, Хувь нийлүүлэгчдийн төлөөлөгч буюу төлөөлөгчид хүрэлцэн ирсэн бол ирц бүрдэнэ.

# Оюу Толгой Төслийн Хувь Нийлүүлэгчдийн Гэрээ

---

## 4.11 Хувь нийлүүлэгч санал өгөх

Хувь нийлүүлэгч бүр өөрийн эзэмшилд буй хувьцааны тоотой тэнцүү санал өгөх эрхтэй.

## 5. Нэгдмэл Сонирхолтой Хэлцэл

---

- а) Энэхүү гэрээний 5(б)-р зүйлд зааснаас бусад нөхцөл байдалд Монгол Улсын Компанийн тухай хуулийн (энэхүү гэрээг байгуулах өдөр хүчин төгөлдөр байсан) сонирхлын зөрчилтэй хэлцлийн тухай заалтууд түүний дотор уг хуулийн 12-р бүлгийн заалтууд Компанийн үйл ажиллагаанд үйлчилнэ.
- б) Монгол Улсын Компанийн тухай хуулийн сонирхлын зөрчилтэй хэлцлийн тухай заалтууд нь (Компанийн тухай хуулийн 12-р бүлгийг оролцуулан) Компани (нэг талаас) болон аль нэг Хувь нийлүүлэгч, эсхүл аль нэг Хувь нийлүүлэгчийн Нэгдмэл сонирхолтой этгээдийн (нөгөө талаас) хооронд хийсэн хэлцэлд үйлчлэхгүй. Тухайн хэлцэлд дараахи заалтууд үйлчилнэ. Үүнд:
- (i) Компани Хувь нийлүүлэгчдээс урьдчилан зөвшөөрөл авахгүйгээр энэ төрлийн хэлцэл хийж болох боловч уг хэлцэл нь дараах шаардлагыг хангасан байна:
- А. Зах зээлийн үнийн хувьд өрсөлдөхүйц үнээр;
- Б. Нэгдмэл сонирхолгүй этгээдүүдийн хооронд хийх гүйлгээтэй адил арилжааны нөхцлөөр хийгдсэн байх ба;
- В. Уг хэлцлийн талаар Хувь нийлүүлэгчдэд шуурхай мэдэгдсэн байна.
- (ii) ТУЗ-ийн гишүүн бүр энэ төрлийн аливаа хэлцэлд саналаа өгч болно. Хэрэв аль нэг Хувь нийлүүлэгч уг хэлцлийг энэхүү 5(б)(i) зүйлийн шаардлагыг хангаагүй (**Сонирхлын зөрчилтэй хэлцэл**) гэж үзвэл Компани болон бусад Хувь нийлүүлэгчид мэдэгдэл өгч болох ба энэ тохиолдолд дараах заалт үйлчилнэ:
- А. Сонирхлын зөрчилтэй хэлцлийн талаар Хувь нийлүүлэгч мэдсэнээс хойш 30 хоногийн дотор мэдэгдлийг хүргүүлэх ба мэдэгдэлдээ тухайн хэлцэл ямар үндэслэлээр 5(б)(i)-р зүйлд заасан шалгуурыг хангахгүй байгаа шалтгааныг заасан байна.
- Б. Тухайн Сонирхлын зөрчилтэй гүйлгээг дараагийн ТУЗ-ийн хурал дээр хэлэлцэнэ.
- В. Хэрэв Хувь нийлүүлэгч ТУЗ-ийн хурал дээр хэлэлцсэн Сонирхлын зөрчилтэй хэлцэлд сэтгэл ханамжгүй байгаа бол тэрээр энэ тухайгаа дурдсан мэдэгдлийг хурал болсноос хойш 7 хоногийн дотор нөгөө Хувь нийлүүлэгчдээ болон ТУЗ-д өгч дараа нь Хувь нийлүүлэгчид хамтран тухайн хэлцэл 5(б)(i) зүйлийн шаардлагыг хангаж байгаа эсэх талаар үнэлгээ хийлгэхээр зохих шаардлага хангасан хараат бус шинжээчийг томилно.

# Оюу Толгой Төслийн Хувь Нийлүүлэгчдийн Гэрээ

---

- Г. Хэрэв Хувь нийлүүлэгчид 5(б)(ii) (B)-р зүйлд заасан мэдэгдэл өгснөөс хойш 15 хоногийн дотор хараат бус шинжээчийг томилох талаар зөвшилцөлд хүрээгүй тохиолдолд тухайн шинжээчийг Хувь нийлүүлэгчдийн зөвшөөрснөөр олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдсөн, нэр хүндтэй аудитын байгууллагаас томилно.
- Д. Хэрэв хараат бус шинжээч Сонирхлын зөрчилтэй хэлцлийг 5(б)(i)-р зүйлийн шаардлагыг хангахгүй байна гэж үзвэл уг хэлцлийг хүчингүйд тооцохгүй боловч тухайн Сонирхлын зөрчилтэй хэлцлийн нэг Тал болох Хувь нийлүүлэгч (эсхүл Сонирхлын зөрчилтэй хэлцлийн нэг тал болсон Нэгдмэл сонирхолтой этгээд нь ) 5(б)(i)-р зүйлийн заалтын шалгуурыг хангаагүйн улмаас Компанид учирсан хохирлыг хариуцна.
- Е. Хэрэв хараат бус шинжээч Сонирхлын зөрчилтэй хэлцлийг 5(б)(i)-р зүйлийн шаардлагыг хангасан гэж үзвэл 5(б)(ii)(B)-р зүйлд заасан мэдэгдэл өгсөн Хувь нийлүүлэгч уг шинжээчтэй холбогдон гарах бүх зардлыг хариуцна.

## 6. Удирдлагын баг

---

### 6.1 Удирдлагын багийг томилох

Айвенхоу өөрийгөө эсвэл өөрийн нэгдмэл сонирхолтой этгээдийг Компанийн үйл ажиллагаа, түүний дотор Үндсэн үйл ажиллагааг удирдан зохион байгуулах Удирдлагын багаар томилуулахаар нэр дэвшүүлж болох ба ТУЗ уг этгээдийг (*Удирдлагын баг*) томилно. Айвенхоу уг Удирдлагын багийг орлох өөр багийг хэдийд ч санал болгож болох ба ТУЗ тухайн орлох багийг томилох шийдвэр гаргаж болно.

### 6.2 Удирдлагын багийн үйл ажиллагаа

- а) Удирдлагын баг нь ТУЗ-өөс баталсан хөтөлбөр, төсөв, өгсөн заавар чиглэлийн хүрээнд Компанийн үйл ажиллагаа, түүний дотор Үндсэн үйл ажиллагааг бүхэлд нь удирдан зохион байгуулахад шаардлагатай бүхий л эрхтэй байна.
- б) ТУЗ нь Удирдлагын багийн үйл ажиллагаанд хяналт тавьж, шаардлагатай үед зохих асуудлаар харьцаж ажиллана. Удирдлагын баг Компанийн үйл ажиллагаа, түүний дотор Үндсэн үйл ажиллагаатай холбогдуулан ТУЗ-д улирал бүр бичгээр тайлагнаж байна. 4.6(a) зүйлд заасны дагуу Удирдлагын багийн төлөөлөгч ТУЗ-ийн улирал бүрийн хуралд оролцоно. Тайланг тухайн улирал дууссанаас хойш 30 хоногийн дотор ТУЗ-д хүргүүлнэ.

### 6.3 Менежментийн төлбөр

- а) Компани нь Удирдлагын багт Гэрээний энэхүү 6.3 дугаар зүйлд заасан менежментийн төлбөрийг төлнө.
- б) Менежментийн төлбөрийг улирал бүрийн эцэст тооцож, дараагийн улирлын эхний сарын ажлын эхний 10 өдрийн дотор нөхөн төлнө.
- в) Компаниас төлөх менежментийн төлбөрийн хэмжээ дараах болно:



# Оюу Толгой Төслийн Хувь Нийлүүлэгчдийн Гэрээ

---

- (i) Урьдчилсан нөхцөл бүрэн хангагдсан өдрөөс эхлэн Хөрөнгө оруулалтын гэрээний 3.2.2-р зүйлд зааснаар ил уурхайгаас бүтээгдэхүүн үйлдвэрлэж эхлэх хүртэлх хугацааны төлбөр нь тухайн хугацаанд зарсан хөрөнгө оруулалтын болон үйл ажиллагааны зардлын 3% (хувь),
  - (ii) Ил уурхайгаас бүтээгдэхүүн үйлдвэрлэж эхэлснээс хойшхи хугацааны төлбөр нь хөрөнгө оруулалтын болон үйл ажиллагааны зардлын 6% (хувь)-тай тус тус тэнцүү байна.
- г) Компаниас төлөх менежментийн төлбөрийг Монгол Улсын аж ахуйн нэгжийн албан татвар ногдох орлогоос хасагдах зардалд оруулж тооцно.
  - д) Санхүүгийн жилийн аудитаар баталгаажуулсан санхүүгийн тайлан бэлэн болсны дараа Хувь эзэмшигчид нь тухайн тайланд тусгасан хөрөнгө оруулалтын болон үйл ажиллагааны зардлыг тухайн санхүүгийн жилийн менежментийн төлбөрийн хэмжээг тогтооход тооцсон хөрөнгө оруулалтын болон үйл ажиллагааны зардлын гүйцэтгэлтэй тулган тооцож нийлнэ. Хэрэв зөрүү гарвал Компани болон Удирдлагын баг нь тухайн Санхүүгийн жилд төлсөн менежментийн төлбөрийн зөрүүг шуурхай төлнө.
  - е) Удирдлагын баг нь Айвенхоугийн нэгдмэл сонирхолтой этгээдэд менежментийн үүргээ бүхэлд нь буюу хэсэгчлэн гэрээгээр буюу томилон шилжүүлж болно. Энэ тохиолдолд менежментийн төлбөрийн зохих хэсгийг (Удирдлагын баг тодорхойлсноор) Компани нь тухайн нэгдмэл сонирхолтой этгээдэд шилжүүлнэ.
  - ж) Санхүүгийн жил бүрийн календарийн сүүлийн улиралд ТУЗ Удирдлагын багийн тухайн санхүүгийн жилийн үйл ажиллагааг үнэлнэ.
  - з) Айвенхоу нь Удирдлагын багийн нэрийн өмнөөс энэхүү Гэрээг хэрэгжүүлэхтэй холбогдсон (түүний дотор энэхүү Гэрээний 16 дугаар зүйлд заасан маргааны талаар мэдэгдэл гаргах) арга хэмжээг авч болно.

## 7. Төсөв ба санхүүгийн талаарх мэдээлэл

---

### 7.1 Жилийн төлөвлөгөө, төсөв

- а) Гэрээ бүрэн хүчин төгөлдөр болсны дараа ажлын 10 өдрийн дотор Компани нь тухайн санхүүгийн жилийн анхны хөтөлбөр, төсвийг боловсруулан ТУЗ-д хүргүүлэх ба ТУЗ хуралдаж уг хөтөлбөр, төсвийн талаар шийдвэр гаргана.
- б) Санхүүгийн жил эхлэхээс өмнө Компани нь тухайн санхүүгийн жил дэх үйл ажиллагааны хөтөлбөр болон төсвийн талаарх дэлгэрэнгүй төслийг батлуулахаар ТУЗ-д бэлдэж хүргүүлнэ.
- в) Тухайн санхүүгийн жил эхлэхээс наад зах нь 30 хоногийн өмнө ТУЗ нь хөтөлбөр, төсөв нэг бүрийг хянан үзэж, шийдвэр гаргасан байна. Хөтөлбөр ба төсвийг батлах нь Компани болон Удирдлагын багийн хувьд тухайн хөтөлбөр төсвийг хэрэгжүүлэхийн тулд шаардлагатай бүх арга хэмжээг авч, бүх зардал гаргах зөвшөөрөл болно.

# Оюу Толгой Төслийн Хувь Нийлүүлэгчдийн Гэрээ

---

- г) Хэрэв нөхцөл байдал шаардвал Компани нь ТУЗ-д хөтөлбөр, төсөвт нэмэлт өөрчлөлт оруулах саналыг бэлдэж хүргүүлж болно.

## 7.2 Санхүүгийн мэдээлэл

Компани нь ТУЗ-ийн гишүүн болон Хувь нийлүүлэгчдэд дараах мэдээллийг заавал гаргаж өгнө:

- а) Сар болгоны эцэст аудитаар баталгаажуулаагүй менежментийн мэдээ;
- б) Санхүүгийн жилийн эцэст Компанийн аудитаар баталгаажуулсан санхүүгийн тайлан;
- в) Хувь нийлүүлэгч болон ТУЗ-ийн аль нэг гишүүнээс хэдийд ч, үндэслэлтэй шаардаж болох бусад мэдээлэл.

## 8. Компанийн санхүүжилт

---

### 8.1 Санхүүжүүлэх хүсэлт

- а) ТУЗ-өөс баталсан хөтөлбөр, төсвийн хүрээнд Компанийн төлөвлөж буй үйл ажиллагааны санхүүжилтийн шаардлагыг хангах үүднээс Хувь нийлүүлэгчдээс өөрийн эзэмшлийн хувь хэмжээнд тохируулан санхүүжилт хийхийг Компани нь энэ Гэрээний 8.8 дугаар зүйлд заасны дагуу бичгээр хүсэж болно (цаашид **Санхүүжүүлэх хүсэлт** гэх).
- б) Хувь нийлүүлэгчид нь мөн гэрээний 3.4-р зүйлд заасан өөрсдийн эзэмшлийн хувь хэмжээнд тохируулан зохих хугацаанд санхүүжилтийг энэхүү Гэрээний 8.4 (а)-р зүйлийн хүрээнд хийнэ. Үүний дагуу Компанийн хувьцааг Хувь нийлүүлэгч бүрт дараах байдлаар олгохыг Талууд зөвшөөрөв. Үүнд:
  - (i) Санхүүжилтийг Хувь нийлүүлэгч өөрөө, эсхүл түүний нэрийн өмнөөс санхүүжилт хийсэн бол тухайн хувь хэмжээнд нийцүүлэн олгоно;
  - (ii) ижил ангиллын хувьцааг адил тэгш нөхцөлтэйгээр олгоно.
- в) ТУЗ өөрөөр шийдээгүй бол Санхүүжүүлэх хүсэлтийн дагуу хийх бүх санхүүжилтийг АНУ-ын доллараар хийнэ. ТУЗ-өөс шийдвэр гаргасан бол 8.1(а)-р зүйлийн дагуу хүргүүлсэн Санхүүжүүлэх хүсэлтийн мэдэгдэлд заасан валютаар Талууд санхүүжилтээ хийнэ.

### 8.2 Санхүүжүүлэх хүсэлтийн үечлэл

- а) Гэрээ бүрэн хүчин төгөлдөр болох өдөр болон түүнээс хойш Гэрээний 8.1 дүгээр зүйлд заасан санхүүжилт хийх хүсэлтийг улирал тутам тавих бөгөөд тухайн улирал эхлэхээс өмнө Хувь нийлүүлэгчдэд хүргүүлсэн байна.
- б) 7.1(а)-д заасан хөтөлбөр, төсвийг баталмагц тухайн хөтөлбөр, төсөвт тусгасан зардлыг санхүүжүүлэхээр эхний хүсэлт гаргаж болно.

### 8.3 Санхүүжилтийн хугацаа

Гэрээний 8.1 дүгээр зүйлд заасны дагуу санхүүжилт хийх хүсэлт хүлээн авснаас 30 хоногийн дотор Санхүүжүүлэх дүнгийн төлбөрийг Компанид хийнэ.

# Оюу Толгой Төслийн Хувь Нийлүүлэгчдийн Гэрээ

---

## 8.4 ТӨК-ийн нэрийн өмнөөс санхүүжилтийг хийх

- а) Санхүүжүүлэх дүн тус бүрийн хувьд ТӨК нь:
  - (i) төлбөрийг өөрөө бүрэн буюу хэсэгчлэн хийх; эсхүл
  - (ii) Гэрээний 8.4(с)-д заасны дагуу төлбөрийг Айвенхоугаар бүрэн хийлгэх буюу өөрөө хэсэгчлэн хийх бол дутуу төлбөр (Дутуу төлбөр гэнэ) хийсэн хэсгийг төлүүлэхийг хүсэх үүрэгтэй.
- б) ТӨК нь 8.4 (а)-д заасан хувилбарын аль нэгийг сонгосон тухайгаа Компани болон Айвенхоуд бичгээр мэдэгдэнэ.
- в) Энэхүү Гэрээний 8.4(г)-ийн хүрээнд ТӨК нь түүний нэрийн өмнөөс уг төлбөрийг Айвенхоугаар бүхэлд нь хийлгэх, эсвэл Дутуу төлбөрөө хийлгэхийг хүссэн бол Айвенхоу өөрөө эсвэл түүний томилсон төлөөлөгч түүний дотор Айвенхоугийн нэгдмэл сонирхолтой этгээд нь тухайн Санхүүжилтийг мэдэгдэлд заасны дагуу бүхэлд нь буюу хэсэгчлэн төлөх арга хэмжээ авна. (Ийнхүү санхүүжилт хийсэн этгээдийг цаашид **Айвенхоугийн санхүүжүүлэгч** гэх ба ийнхүү хийсэн төлбөрийг **Санхүүжүүлсэн дүн** гэнэ)
- г) Санхүүжилтийн хугацаа дуусмагц тус 8 дугаар зүйлд заасны дагуу ТӨК-ийн өмнөөс санхүүжилт хийх Айвенхоугийн үүрэг дуусгавар болно.
- д) ТӨК нь энэхүү Гэрээний 10.6 дугаар зүйлд заасны дагуу 100% Төрийн өмчлөл, удирдлага, хяналтад байгаа тохиолдолд Айвенхоу нь ТӨК-ийн нэрийн өмнөөс санхүүжилт хийх үүрэг хүлээнэ.
- е) ТӨК санхүүжүүлэх хүсэлтийн дагуу төлбөр төлөх тухай мэдэгдлийг хүлээн авснаар 8.1 (б)-ийн дагуу хүсэлтээ ажлын 5 өдрийн дотор ирүүлээгүй бол түүний нэрийн өмнөөс уг төлбөрийг хийх хүсэлтийг ТӨК Айвенхоуд тавьсанд тооцно.
- ж) Хэрэв тухайн санхүүжүүлэх хүсэлтийн дагуу 8.4 (в) дүгээр зүйлд заасан төлбөрийг Айвенхоу хийгээгүй бол тэрхүү төлбөрийг хийгээгүй хувьцааг Хувь эзэмшигчдэд компаниас гаргаж олгохгүй.

## 8.5 Санхүүжүүлсэн дүн

Айвенхоугийн Санхүүжүүлсэн дүн нь 8.6–д заасан хүүгийн хамт ТӨК-иас Айвенхоугийн санхүүжүүлэгчид (эсвэл түүний нэрийн өмнөөс Айвенхоуд) төлөх өр болно. Тэрхүү өрийг 10.6(в) болон 10.7(б) дугаар зүйлд зааснаас (ТӨК нь Төрийн өмчлөл, удирдлага, хяналтаас гарахаас ) бусад тохиолдолд зөвхөн ногдол ашгаас төлж барагдуулна.

## 8.6 Хүү

- а) Гэрээний 8.6(в)(ii)-д заасан Үлдэгдэл төлбөрийн өрийн үлдэгдэл дүнг улирал тутам тооцох ба түүнд ногдох хүүг улирал тутам тухайн улиралд нь зохих хүүгийн ханшаар тооцно.
- б) Энэхүү 8.6 (а)-ийн зорилгоор хүүг тухайн хугацааны өдрөөр тооцох ба жилд 360 өдөр байна гэж үзнэ. Хэрэв улирал, ажлын өдрөөр дуусгавар болоогүй бол тухайн өдрийг дараагийн ажлын өдрөөр сунгаж тооцно.

# Оюу Толгой Төслийн Хувь Нийлүүлэгчдийн Гэрээ

---

- в) Энэхүү Гэрээний хүрээнд:
- (i) улирал тутмын **Хүү гэдэг нь** тухайн улирлын ЛИБОР хүү дээр 3.3 хувийн хүүг нэмэгдүүлснийг хэлнэ.
  - (ii) **Үлдэгдэл төлбөр** гэдэг нь аль нэг хугацаанд хуримтлагдсан дараах төлбөр болон тэдгээрээс 8.7-р зүйлд заасны дагуу ТӨК-иас төлж барагдуулсан төлбөрийг хассан үлдэгдлийг хэлнэ:
    - (А) Айвенхоугийн санхүүжүүлэгчээс төлсөн Санхүүжилт;
    - (В) Тухайн цаг хугацаанаас өмнө хуримтлагдсан, гэрээний 8.6-р зүйлд заасан хүү тус тус болно.
  - (г) Үлдэгдэл төлбөрийн тооцоог ТӨК болон Айвенхоу нь жил бүр хамтран нийлнэ.

## 8.7 Үлдэгдэл төлбөрийг төлөх

- а) Энэхүү Гэрээний 9.2 дугаар зүйлд заасны дагуу бүх өрийн үлдэгдэл дүнг бүрэн төлөх хүртэл ТӨК-ийн эзэмшилд буй хувьцаанд төлөгдөх бүх ногдол ашгийг Компани нь Айвенхоугийн санхүүжүүлэгчид (эсвэл түүний нэрийн өмнөөс Айвенхоуд) төлнө.
- б) Энэхүү 8.7а) заалтыг хэрэгжүүлэх зорилгоор Гэрээний 9.2 дугаар зүйлд заасны дагуу бүх өрийн үлдэгдэл дүнг бүрэн төлөх хүртэл ТӨК-ийн эзэмшилд буй хувьцаанд төлөгдөх бүх ногдол ашгийг Компани нь Айвенхоугийн санхүүжүүлэгчид (эсвэл түүний нэрийн өмнөөс Айвенхоуд) төлөх үүргийг ТӨК нь Компанид үүгээр эргэлт буцалтгүй өгч байна.
- в) Энэхүү 8.7 дугаар зүйлд заасны дагуу төлсөн төлбөрийн хэмжээгээр үлдэгдэл өр буурна.

## 8.8 Төслийн санхүүжилтийг Гуравдагч этгээдээс авах

- а) Компанийн төлөвлөгдсөн мөнгөний хэрэгцээг олон улсын хүлээн зөвшөөрөгдсөн санхүүгийн байгууллагаас зээлэх замаар санхүүжүүлэхээр ТУЗ хэдийд ч шийдэж болно.
- б) Энэхүү 8.8а) зүйлд заасан Төслийн санхүүжилтийг олон улсын банк санхүүгийн зах зээлийн хамгийн сайн нөхцлөөр, Хувь нийлүүлэгчид болон тэдний хөрөнгөөр бус зөвхөн Төслийн хөрөнгөөр баталгаажуулан хийсэн тохиолдолд авна.

## 8.9 Гэрээний 8-р зүйлийн заалт үйлчлэхгүй байх

Гэрээний 4.10(а) болон Компанийн хуулийн 26.1-р зүйлд заасны дагуу Компанийг татан буулгах ажиллагаа эхэлсэн бол энэхүү 8 дугаар зүйлийн заалтын үйлчлэл зогсоно.

## 9. Ногдол ашиг хувиарлах

---

### 9.1 Ногдол ашиг төлөх

- а) Хэрэв санхүүгийн аливаа жилд Компани ашигтай ажилласан бол хуримталсан ашгийн 50 –иас доошгүй хувийг тухайн санхүүгийн жилийг дууссанаас хойш 3

# Оюу Толгой Төслийн Хувь Нийлүүлэгчдийн Гэрээ

---

сарын дотор ногдол ашгийн хэлбэрээр хуваарилна. Гэхдээ уг асуудлыг Компанийн ирээдүйн мөнгөн урсгалын хэрэгцээ (түүний дотор уурхайн хүчин чадал, үйл ажиллагааг өргөжүүлэх зардал, эргэлтийн хөрөнгийн шаардлага, үндсэн хөрөнгийн засвар үйлчилгээний зардал болон бусад шаардлагатай зардал г.м.) зэргийг харгалзан үзэж шийдвэрлэнэ.

- б) 9.1 (а) зүйлд зааснаас бусад тохиолдолд аль ч Хувь нийлүүлэгч Компанийн ногдол ашиг болон орлогоос төлбөр гаргуулахаар дайчлах эрхгүй.
- в) 9.1 (а) зүйлд заасан ногдол ашиг төлөх эсэхийг Компанийн жилийн үйл ажиллагааны аудитаар баталгаажуулсан тайланд тулгуурлан шийднэ.
- г) ТУЗ нь хугацаанаас өмнө ногдол ашиг төлөх шийдвэр гаргаж болно.

## 9.2 ТӨК-д төлөх ногдол ашгийг хуваарилах

- а) Компаниас аливаа ногдол ашгийг ТӨК-т төлөхдөө дараах дарааллыг баримтална:
  - (i) эхлээд Үлдэгдэл төлбөрийг төлөх;
  - (ii) дараа нь ТӨК-т төлнө.
- б) Компани нь энэхүү 9.2 (а) (i)-р зүйлд заасны дагуу Айвенхоугийн санхүүжүүлэгчид төлбөр төлөх нь ТӨК-д ногдол ашиг төлөх үүргээ биелүүлж буйтай ижил тооцогдоно.

## 10. Хувьцаа шилжүүлэх ба бүртгэх

---

### 10.1 Хувьцаа шилжүүлэх зөвшөөрөл

Энэхүү Гэрээнд тусгайлан заагаагүй бол аль нэг Хувь нийлүүлэгч нь нөгөө Хувь нийлүүлэгчийн (*Нөгөө Хувь нийлүүлэгчийн*) зөвшөөрлийг бичгээр урьдчилан авалгүйгээр хувьцаагаа бүхэлд нь, эсвэл хэсэгчлэн (эсвэл тухайн бүх хувьцаа ба түүний аль нэг хэсэгт ногдох сонирхлыг) захиран зарцуулахгүй.

### 10.2 Хувьцаа шилжүүлэхтэй холбогдуулан тэргүүн ээлжинд эдлэх эрх

- а) Энэхүү Гэрээний 10.2б)-ээс (и) -д заасны дагуу Хувь нийлүүлэгч нь өөрийн хувьцааг бүхэлд нь эсвэл хэсэгчлэн мөн Гэрээний 10.3 ба 10.7 дугаар зүйлийн хүрээнд шилжүүлж болно.
- б) Хэрэв хувьцаа шилжүүлэгч этгээд нь өөрийн хувьцааг бүхэлд нь буюу хэсэгчлэн гуравдахь этгээдэд шилжүүлэх хүсэлтэй (**Захиран зарцуулах хувьцаа**) бол энэхүү Захиран зарцуулах хувьцаанд хамрагдаж буй хувьцаагаа Нөгөө Хувь нийлүүлэгч бүрт эхэлж санал болгоно.
- в) 10.2 (б)-д заасан Шилжүүлэгч этгээд нь шилжүүлэх мэдэгдлээ (*Шилжүүлэх мэдэгдэл*) бичгээр хүргүүлэх бөгөөд Шилжүүлэх мэдэгдэлд дараах зүйлсийг тусгасан байна.
  - (i) Захиран зарцуулах хувьцааы тоо, түүний үнийг АНУ-ын доллараар. (*Шилжүүлэх үнэ*);

## Оюу Толгой Төслийн Хувь Нийлүүлэгчдийн Гэрээ

---

- (ii) Захиран зарцуулах хувьцааг ямар нөхцлөөр худалдахаар санал болгож байгаа болон;
  - (iii) Бусад хувь нийлүүлэгчид Шилжүүлэгчийн саналыг хүлээж аваагүй тохиолдолд Захиран зарцуулах хувьцаагаа шилжүүлэхээр санал болгож буй гуравдагч этгээд (*Томилогдсон гуравдагч этгээд*).
- г) Шилжүүлэх мэдэгдэл нь түүнд заасан нөхцлийн дагуу Захиран зарцуулах хувьцааг худалдах, буцах нөхцөлгүй санал болох бөгөөд Нөгөө Хувь нийлүүлэгчдэд мэдэгдлийг хүргүүлснээс хойш ажлын 50 өдрийн дотор хариу өгөх эрх нь нээлттэй байна (*Санал болгох хугацаа*).
- д) Санал болгох хугацаанд Нөгөө Хувь нийлүүлэгчдийн аль нэг нь Шилжүүлэх мэдэгдэлд дурьдсан хувьцааг худалдан авахаас татгалзаж байгаа, эсвэл саналыг хүлээж авч байгаа эсэхээ Шилжүүлэгч этгээдэд (мөн бусад Хувь нийлүүлэгчдэд хувийг) бичгээр хүргүүлнэ. Хэрэв нэгээс олон хувь нийлүүлэгч байгаа бол Захиран зарцуулах хувьцааг тэдгээрт бүгдэд нь санал болгосонд тооцно. Хэрэв нэгээс дээш хувь нийлүүлэгч саналыг хүлээж авбал тэд уг сонирхлыг хамтдаа биш харин тус тусдаа, өөрсдийн хувь эзэмшилд тохируулан (эсвэл үлдсэн хувь нийлүүлэгчид өөрөөр тохирч шилжүүлэх этгээдэд мэдэгдсэн эзэмшиж буй хувь хэмжээгээр) худалдан авна.
- е) Хэрэв нэг буюу түүнээс дээш бусад хувь нийлүүлэгчид саналыг хүлээж авахгүй бол бусад үлдсэн хувь нийлүүлэгчид өөрсдийн хувь эзэмшлийн харьцаанд тохируулан (эсвэл нөгөө хувь нийлүүлэгчид өөрөөр тохирч шилжүүлэх этгээдэд мэдэгдсэн эзэмшиж буй хувь хэмжээгээр) худалдан авч болно.
- ж) Хэрэв Нөгөө Хувь нийлүүлэгчдийн аль нэг нь Захиран зарцуулах хувьцааг 10.2 (д) болон 10.2 (е) заалтын дагуу нийтэд нь хүлээж аваагүй бол санал болгох хугацаа дуусмагц Шилжүүлэх мэдэгдэлд дурьдсан саналаас татгалзсанд тооцно.
- з) Шаардлагатай зөвшөөрөл авахаас бусад тохиолдолд 10.2б)-д заасан саналыг хүлээж авсан бол эргэж буцалтгүй байна.
- и) Хэрэв Нөгөө Хувь нийлүүлэгчдийн аль нэг нь Захиран зарцуулах хувьцаанд хамрагдах хувьцааг бүгдийг нь худалдаж авахаар зөвшөөрвөл саналын хугацаанаас хойшхи ажлын 10 дахь өдөр хувьцаа шилжүүлэх бүх ажиллагаа дуусгавар болсон байх ёстой ба Захиран зарцуулах хувьцааг Шилжүүлэх үнээр Шилжүүлэгч нь худалдаж, тухайн Нөгөө Хувь нийлүүлэгч нь худалдан авна.
- к) Энэхүү зүйлийн 10.2б)-ээс (з)-д заасны дагуу Захиран зарцуулах хувьцааг худалдан авах саналыг хүлээн авах тухай мэдэгдэл ирээгүй бол Шилжүүлэгч нь 10.7-р зүйлд заасны дагуу Захиран зарцуулах хувьцаагаа бүхэлд нь (харин аль нэг хэсэг нь байж болохгүй) саналын хугацаа дууссанаас хойш 90 хоногийн дотор Томилогдсон гуравдагч этгээдэд Шилжүүлэх үнээс доошгүй үнээр, Шилжүүлэх мэдэгдэлд заасан нөхцлөөс дутуугүй нөхцлөөр шилжүүлж болно.
- л) Санал болгох хугацаа дууссанаас 90 хоногийн дотор Захиран зарцуулах хувьцааг шилжүүлээгүй бол Шилжүүлэгч нь Захиран зарцуулах хувьцаагаа 10.2б)-ээс (з)-д заасан шаардлагыг эхэлж хангахгүйгээр бусдад шилжүүлж болохгүй.

## Оюу Толгой Төслийн Хувь Нийлүүлэгчдийн Гэрээ

---

### 10.3 Айвенхоу болон Рио Тинто группийн аливаа гишүүний хооронд Хувьцаа шилжүүлэхийг зөвшөөрөх

Хувь нийлүүлэгч болох, Айвенхоу болон Рио Тинто группийн аливаа гишүүн нь өөрийн эзэмшиж буй хувьцааг, бусад Хувь нийлүүлэгчдээс урьдчилан бичгээр зөвшөөрөл авахгүйгээр, эсвэл 10.2 дугаар зүйлд заасан шаардлагыг хангаснаар тухайн группийнхээ аль нэг гишүүнд бүхэлд нь (эсвэл хэсэгчлэн) шилжүүлж болно

---

### 10.4 Хувьцааг барьцаалах тухай

Аль нэг Хувь нийлүүлэгч нь 10.5-д зааснаас бусад тохиолдолд өөрийн эзэмшлийн хувьцаагаа бусдад ямар нэг хэлбэрээр барьцаа болгож, үнэт цаасны сонирхол буй болгохгүй.

---

### 10.5 Хувьцааг барьцаалах

- а) Зөвхөн дараахь нөхцөлд Хувь нийлүүлэгч нь өөрийн эзэмшилд буй хувьцааг барьцаалж болно. (*Зөвшөөрөгдсөн барьцаа*):
- (i) хувьцааг олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдсөн санхүүгийн байгууллагад Хувьцаа эзэмшигчдийн хооронд тохирсны дагуу барьцаалах (*Зөвшөөрөгдсөн барьцаалагч*);
  - (ii) Тухайн Хувь нийлүүлэгч ТУЗ-д бичгээр урьдчилсан мэдэгдсэн бөгөөд;
  - (iii) дараахи шаардлагыг юуны өмнө хангасан байна. Үүнд:
    - А) Зөвшөөрөл бүхий барьцааг бичгээр үйлдэх ба энэхүү 10.5-р зүйлд заасан шаардлагыг тусгана.
    - Б) Зөвшөөрөл бүхий барьцааны нэг хувийг Хувь нийлүүлэгч бүрт тухайн баримт бичигт гарын үсэг зурахаас ажлын 30 хоногийн өмнө хүргүүлсэн байх ба бусад Хувь нийлүүлэгчдийн урьдчилсан бичгээр өгсөн зөвшөөрөлгүйгээр гарын үсэг зурахаас өмнө болон дараа нь ямар нэг байдлаар өөрчлөхгүй.
    - В) Зөвшөөрөгдсөн барьцаалагч нь бүх Хувь нийлүүлэгчид болон Компанийн хүлээж авахуйц хэлбэрээр баталгааг гаргаж хүргүүлэх ба үүнд тухайн Барьцаалуулагч нь:
      - (1) энэхүү Гэрээний дагуу эрх эдэлнэ;
      - (2) энэхүү Гэрээний 8.7 болон 9.2-т заасны дагуу ТӨК-т төлөх ногдол ашгийг Айвенхоу болон Айвенхоугийн санхүүжүүлэгч авсны дараа тухайн Барьцаалуулагчийн эрхээ эдлэх боломж нээгдэнэ гэдгийг тус тус хүлээн зөвшөөрнө.
- (б) Зөвшөөрөгдсөн барьцаа нь:
- (i) энэхүү Гэрээний дагуу Хувь нийлүүлэгч этгээдэд олгогдох аливаа эрх, түүний дотор өр төлбөр (үүнд Үлдэгдэл төлбөр) хүлээн авах эрхийг ямар нэг байдлаар хөндөхгүй;

# Оюу Толгой Төслийн Хувь Нийлүүлэгчдийн Гэрээ

---

- (ii) Зөвшөөрөл бүхий сонирхлыг эзэмшигч нь (эсвэл түүгээр дамжуулан эрх ашгаа илэрхийлж буй этгээд) уг сонирхлыг худалдах эсвэл өөр байдлаар эзэмшиж буй сонирхлоо захиран зарцуулах болвол уг үйл ажиллагаа нь тус 10.2 дугаар зүйлд захирагдана;
- (iii) Гэрээний 8.7 болон 9.2-р зүйлийн дагуу ТӨК-д төлбөл зохих ногдол ашгийг Айвенхоу болон Айвенхоуийн санхүүжүүлэгч тэргүүн ээлжинд авах эрхээр Барьцаалуулагчийн эрх хязгаарлагдана гэдгийг тус тус тодорхой заана.

## 10.6 ТӨК-ийн төрийн өмчлөл ба хувьцааг хөрөнгийн биржид арилжих.

- (a) 10.6(б) д зааснаас бусад тохиолдолд ТӨК нь Төслийн бүх хугацааны туршид:
  - (i) 100 % Төрийн өмчлөлд байх; ба
  - (ii) Зөвхөн Төрийн удирдлага, хяналтад байна.
- (б) Төр ТӨК дахь хувьцаагаа Монголын Хөрөнгийн бирж болон олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдсөн хөрөнгийн биржид гаргаж арилжиж болно
- (в) Хэрэв ТӨК нь Төрийн өмчлөлөөс больсон, эсвэл Төрийн удирдлага, хяналтанд байхаа больвол ТӨК нь Айвенхоугаас мэдэгдэл ирмэгц тухайн үед үлдэгдэл төлбөрийг Айвенхоугийн санхүүжүүлэгч (Айвенхоугаас зааварчилсан бол Айвенхоугийн санхүүжүүлэгчийг төлөөлөн Айвенхоу)-д нэн даруй төлөх үүрэг хүлээнэ.

## 10.7 Хувьцааг захиран зарцуулахад тавигдах бусад хязгаарлалт

Хувь нийлүүлэгчид дор зааснаас бусад тохиолдолд өөрийн эзэмшлийн хувьцааг бүхэлд нь эсвэл хэсэгчлэн захиран зарцуулахыг хориглоно. Хувьцаа шилжүүлсэнийг бүртгэхээс өмнө дараахь нөхцлийг хангасан байна:

- (a) Хэрэв хувьцааг энэхүү Гэрээний Тал болох Хувь нийлүүлэгчид шилжүүлээгүй бол тэрхүү эрх шилжүүлэн авагч нь Шилжүүлэгчийн үүргийг бүрэн хүлээж авч биелүүлэхээ илэрхийлж талуудын хүлээн авч болохуйц хэлбэрээр үйлдэгдсэн Хүлээн авах баримт бичигт тус Гэрээний бусад Талуудтай хамтран гарын үсэг зурна.
- (б) 10.7(в) заалтын хүрээнд Шилжүүлэгчийн бусад Хувь нийлүүлэгчид болон Компанид төлөх ёстой байсан бүх өр төлбөр (жишээлбэл, ТӨК-ийн хувьд шилжүүлэх үеийн нийт үлдэгдэл өр төлбөр)-ийг Шилжүүлэн авагч нь энэхүү Гэрээний нөхцлийн дагуу төлөх арга хэмжээ авна.
- (в) Шилжүүлэн авагч нь шаардлагатай бүх зөвшөөрлийг олж авна.

## 10.8 Шилжүүлэхийг хүчингүйд тооцох

Энэхүү 10 дугаар зүйлийг зөрчиж хийсэн аливаа шилжүүлгийг Компани бүртгэхгүй. Ийнхүү хийсэн шилжүүлэг нь хүчин төгөлдөр бус байна.



# Оюу Толгой Төслийн Хувь Нийлүүлэгчдийн Гэрээ

---

## 10.9 Гэрээний дагуу олгогдсон эрхээ шилжүүлэх

Энэхүү 10 дугаар зүйлийн дагуу хувьцаа шилжүүлэхээс бусдаар аль нэг Тал нөгөө Талын бичгээр өгсөн зөвшөөрөлгүйгээр энэхүү Гэрээгээр олгогдсон эрхээ захиран зарцуулахгүй буюу захиран зарцуулахаар оролдохгүй.

## 10.10 Компани дахь хувь хэмжээг нэмэгдүүлэх

Энэхүү гэрээний хугацаанд аль нэг Хувьцаа эзэмшигч нь нөгөө Хувьцаа эзэмшигчдээ хувьцааг нь бүхэлд нь буюу хэсэгчлэн зах зээлийн шударга үнээр, арилжааны үндсэн дээр худалдаж авах асуудлыг хэзээ ч тавьж болно. Аль ч Хувьцаа эзэмшигч нь нөгөө Хувьцаа эзэмшигчдээ хувьцааг нь бүхэлд нь буюу хэсэгчлэн зах зээлийн шударга үнээр, арилжааны үндсэн дээр худалдаж авах саналыг хэзээ ч тавьж болох бөгөөд нөгөө тал нь тухайн саналыг дангаар хүлээж авах буюу татгалзаж болно.

## 11. Баталгаа

---

- а) Гэрээний Талууд нь тус бүртгээ дараахь баталгааг гаргаж байна. Үүнд:
  - (i) Тухайн Тал нь анх байгуулагдсан газрын хууль тогтоомжийн дагуу зохих ёсоор байгуулагдан үйл ажиллагаа явуулж буй хуулийн этгээд болно. (ТӨК-ийн хувьд энэ нь Монгол Улсын хуулийн дагуу зохих ёсоор байгуулагдсан бөгөөд Монгол Улсын Компанийн тухай хуулийн дагуу үйл ажиллагаагаа үргэлжлүүлэн явуулна).
  - (ii) Тухайн Тал нь энэхүү Гэрээнд нэгдэн орж, түүний дагуу үүрэг хүлээж, үйл ажиллагаагаа одоогийн ба ирээдүйд төлөвлөсөн байдлаар явуулах бүрэн эрхтэй болно.
- б) Компани, Хувь нийлүүлэгчид болон тэдний нэгдмэл сонирхолтой этгээд, Удирдлагын багийн Компанийн өмчлөлийн мэдээллийг ТУЗ-өөс тогтоосноор хадгалах үүргээ Талууд заавал биелүүлнэ. ТУЗ-өөс шаардсан бол Хувь нийлүүлэгч бүр өөрийн томилсон ТУЗ-ийн гишүүд, ажилтан, албан хаагч, ажилчин, дэд гэрээлэгч болон тэдний төлөөлөгчид Компанийн өмчлөлийн мэдээллийг хадгалах үүрэг хүлээлгэсэн баримт бичигт гарын үсэг зурж, үүрэг авах явдлыг хангана. Хувь нийлүүлэгч бүр өөрийн томилсон ТУЗ-ийн гишүүд, ажилтан, албан хаагч, ажилчин, дэд гэрээлэгч болон тэдний төлөөлөгчид Компанийн өмчлөлийн мэдээлэл задруулсан, урвуулан ашигласнаас гарах хариуцлагыг хүлээнэ.

## 12. Гэрээний үйлчлэх хүрээ

---

### 12.1 Гэрээ нь Дүрмээс давуу эрхтэй болох талаарх Хувь нийлүүлэгчдийн тохиролцоо

Хэрэв энэхүү Гэрээ болон Дүрмийн заалт нь хоорондоо зөрчилдвөл тухайн зөрчлийн хувьд энэхүү Гэрээний заалтыг баримтлана.

# Оюу Толгой Төслийн Хувь Нийлүүлэгчдийн Гэрээ

---

## 12.2 Гэрээний заалтыг Дүрмийн заалтад тооцох

Энэхүү Гэрээний заалтыг хүчин төгөлдөр байлгах үүднээс Дүрэмд нэмэлт заалт оруулах шаардлагатай гэж үзвэл тухайн заалтыг Дүрэмд оруулах ба цаашид Гэрээний тухайн заалтад нэмэлт өөрчлөлт орвол Дүрмийн холбогдох заалтад мөн нэмэлт өөрчлөлт оруулна.

## 13. Төсөлтэй холбоогүй эдэлбэр, өмчийг шилжүүлэх

---

- а) Хэрэв тус Гэрээг байгуулахаас өмнө хэрэгжүүлж амжаагүй бол Компанийн эзэмшиж буй тусгай зөвшөөрлийн талбайнуудыг шилжүүлж, зөвхөн Оюу Толгой төсөлтэй холбоотой тусгай зөвшөөрлийг үлдээнэ. Ийнхүү бүтцийн өөрчлөлт хийсний дараа Компани нь дараах өмч хөрөнгөтэй байна:
  - (i) 6709А дугаарын ашиглалтын тусгай зөвшөөрөл;
  - (ii) 6708А, 6710А болон 6711А дугаартай ашиглалтын тусгай зөвшөөрөл;болон
  - (iii) 6709А дугаарын тусгай зөвшөөрлийн талбайтай зэрэгцээ буюу эргэн тойрны талбай дахь хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөл бүхий талбайгаас гэрээний дагуу ашиг хүртэх эрх тус тус болно.
- б) Компани нь Оюу Толгой төсөлтэй холбоогүй бусад бүх тусгай зөвшөөрөл, түрээс, бусад эдэлбэр болон тэдгээрт холбогдох хөрөнгийг Айвенхоугоос томилсон Монгол Улсын өөр хуулийн этгээдэд шилжүүлнэ. Иймд тухайн эдэлбэр, эрх болон холбогдох хөрөнгийг Компани эзэмшихгүй.
- в) Энэхүү 13 дугаар зүйлийн дагуу шилжүүлэх ажиллагаа болон гүйлгээ хийхэд шаардагдах Засгийн газрын холбогдох бүх зөвшөөрлийг авснаас хойш ажлын 45 хоногийн дотор уг шилжүүлэх ажиллагаа, гүйлгээг хийж дуусгана.

## 14. Харилцан хариуцлага хүлээх тухай мэдэгдэл

---

### 14.1 Зарчим

- а) Энэхүү Гэрээг зөрчсөн тохиолдолд тухайн зөрчил гаргасан Хувь нийлүүлэгч нь бусад Хувь нийлүүлэгч болон Компанид уг зөрчлөөс учирсан шууд алдагдал, хохирол түүний дотор бүх зардал, хүү, эрх зүйн зардал, шинжээчийн зардал болон бусад төлбөрийг нөхөн төлөх үүрэг хүлээнэ.
- б) Нөхөн төлбөрийг хохирол, алдагдал учирсан эсхүл татвар төлсөн өдрөөс хойш 60 (жар) хоногийн дотор төлнө. Нөхөн төлбөрийг ам.доллараар төлнө.

## 15. Үргэлжлэх хугацаа ба дуусгавар болох

---

### 15.1 Өмнөх Хувь нийлүүлэгчдэд Гэрээ үйлчлэхгүй тухай

Гэрээний 15.3-дугаар зүйлийн хүрээнд энэхүү Гэрээгээр зөвшөөрснөөр бүх хувьцаагаа шилжүүлсэн Хувь нийлүүлэгчийн хувьд энэхүү Гэрээний үйлчлэл дуусгавар болно.

# Оюу Толгой Төслийн Хувь Нийлүүлэгчдийн Гэрээ

---

## 15.2 Гэрээний хугацаа

Энэхүү Гэрээ нь Компанийг бүрэн татан буулгах буюу Талууд бичгээр харилцан тохиролцож уг Гэрээг дуусгавар болгох хүртэл хүчин төгөлдөр үйлчилнэ.

## 15.3 Гэрээ дуусгавар болоход зарим заалтын үйлчилгээг зогсоохгүй байх

Энэхүү Гэрээ болон аливаа Хувь нийлүүлэгчийн хувь эзэмшлийг ямар нэг байдлаар дуусгавар болгох нь:

- а) Ийнхүү дуусгавар болгохоос өмнө Талуудын урьд нь хүлээсэн бөгөөд биелүүлээгүй үүргийн гүйцэтгэлийг зогсоохгүй; ба
- б) Гэрээг дуусгавар болгосноор хүчин төгөлдөр болох буюу хүчинтэй хэвээр байх тухай Гэрээнд тодорхой заасан зүйл заалтын үйлчлэлд нөлөөлөхгүй.

## 16. Маргаан шийдвэрлэх

---

Энэхүү гэрээнээс үүдсэн буюу түүнтэй холбоотой аливаа маргааныг Хөрөнгө оруулалтын гэрээний 13 дугаар зүйлийн дагуу шийдвэрлэх бөгөөд Хөрөнгө оруулалтын гэрээнд заасан Талуудыг энэхүү гэрээний Талууд гэж ойлгоно.

## 17. Бусад заалт

---

### 17.1 Мэдэгдэл

Энэхүү гэрээний дагуу хүргүүлэх болон хийх аливаа мэдэгдэл, шаардлага, зөвшөөрөл болон бусад захидал харилцааг (*Мэдэгдэл*):

- а) бичгээр үйлдэх ба илгээгчийн бүрэн эрх олгосон этгээд гарын үсэг зурсан байх;
- б) хүлээн авагчид төлбөрт шуудангаар (хэрэв гадаад улс руу илгээх бол баталгаат шуудангаар), биеэр, дор дурьдсан хаяг факсын дугаарын дагуу эсвэл хүлээн авагчаас илгээгчид тусгайлан мэдэгдсэн дугаарын дагуу факсаар тус тус илгээнэ.

(i) ТӨК-т: [#]

Хэнд: [#]

Факсын дугаар: [#]

## Оюу Толгой Төслийн Хувь Нийлүүлэгчдийн Гэрээ

---

- (ii) Айвенхоуд: [#]  
Хэнд: [#]  
Факсын дугаар: [#]  
  
(Мэдэгдэлд тооцохгүй) хувийг:  
Айвенхоу Майнз Лимитед  
Канада Плейс 999  
654 тоот  
Ванкувер  
Бритиш Колумбия V6C3E1  
Канад Улс  
Хэнд: Компанийн нарийн бичгийн даргад  
Факс: 604-682-2060  
  
ба  
  
(Мэдэгдэлд тооцохгүй) хувийг:  
Рио Тинто Интернейшнл Холдингс Лимитед:  
Гэгээн Жеймсын талбай 6  
Лондон SW1Y 4LD  
Их Британи Умард Ирландын Нэгдсэн Вант Улс  
Хэнд: Компанийн нарийн бичгийн дарга  
Факс: +44 (0)20 7930 3249
- (iii) Компанид: Сеул бизнесийн төв  
Баянзүрх дүүрэг, 1-р хороо  
Залуучуудын гудамж-26  
Улаанбаатар 210349  
Хэнд: Тэргүүн дэд ерөнхийлөгчид  
Факсын дугаар: [#]

в) Дараах нөхцөлд хүргүүлсэн тооцно:

- (i) биеэр хүргэж өгч буй бол гардуулсан мөчөөс;  
(ii) шуудангаар хүргүүлсэн бол (орон нутагт) шуудангаар илгээснээс хойш ажлын 2 өдрийн дараа, (гадаад оронд) шуудангаар илгээснээс хойш ажлын 7 өдрийн дараа;  
(iii) факсаар явуулсан бол ашигласан факсын машинаас хэвлэн гаргасан, явуулсан хуудасны тоо, хүлээн авагчийн факсын машины дугаар, хүлээн авагчийн нэрийг харуулсан, факс нь алдаагүйгээр дамжуулагдсан болохыг илтгэсэн тайланг илгээгч хүлээн авсан мөчөөс тус тус тооцно,

Хэрэв Мэдэгдлийг илгээсэн буюу хүлээн авсан газрын ажлын бус өдөр хүргүүлсэн, эсвэл тухайн орон нутгийн цагаар 16.00 цагаас хойш хүргүүлсэн бол тухайн орон нутаг болон улсын дараагийн ажлын өдөр ажлын цаг эхлэхэд хүргүүлснээр тооцно.

(г) Мэдэгдэл Англи, Монгол хэл дээр байна.

## Оюу Толгой Төслийн Хувь Нийлүүлэгчдийн Гэрээ

---

### **17.2 Нэмэлт баталгаа**

Энэхүү Гэрээний заалтыг хэрэгжүүлэхэд шаардлагатай буюу тохиромжтой аливаа баримт бичгийг үйлдэж, хүргүүлэх талаар Талууд хамтран ажиллана.

### **17.3 Бүх гэрээ хэлцэл**

Энхүү Гэрээний нөхцөл нь үүгээр зохицуулж буй асуудлаархи Талуудын хүрсэн бүхий л хэлцэл, тохиролцоог хамарч байгаа болно.

### **17.4 Нэмэлт өөрчлөлт**

Энэхүү Гэрээнд зөвхөн Талуудын гарын үсэг зурж, үйлдсэн өөр гэрээгээр нэмэлт, өөрчлөлт оруулж болно.

### **17.5 Үйлчлэх хууль**

Энэхүү гэрээнд өөрөөр тодорхой заагаагүй бол тус Гэрээг Монгол Улсын хуулийн дагуу зохицуулж тайлбарлана.

### **17.6 Хэл**

Энэхүү гэрээг Монгол болон Англи хэл дээр тус бүр гурван эх хувиар үйлдэх ба Талууд хэл тус бүр дээрх нэг хувийг хадгална. Монгол, Англи хэл дээрх хувилбарууд адил хүчинтэй байх ба харин хоёр хэлээр үйлдсэн хувилбарын хооронд зөрөө гарвал Англи хэл дээрх хувилбарыг баримтлахаар Талууд тохиролцов.

## Хавсралт 1

### Нэр томъёоны тодорхойлолт

---

**Хөрөнгийн зардал** гэдэг нь хөрөнгөтэй холбоотой гаргасан, олон улсын нягтлан бодох бүртгэлийн зарчмын дагуу хүлээн зөвшөөрсөн аливаа зардал, төлбөрийг хэлнэ.

**Гэрээ бүрэн хүчин төгөлдөр болох өдөр** гэдэг нь Урьдчилсан нөхцөл бүгд хангагдсан өдрөөс хойш 10 дахь ажлын өдөр буюу Талууд харилцан тохиоролцсон өөр өдрийг хэлнэ.

**Хянах** гэдэг нь аж ахуйн нэгжийн хувьд, тухайн аж ахуйн нэгжийн Хувь нийлүүлэгчдийн хурал дээр шууд буюу шууд бусаар олонхийн санал гаргах эрх, эсвэл тухайн аж ахуйн нэгжийн ТУЗ-ийн гишүүдийн олонхийг шууд буюу шууд бусаар сонгох буюу томилох эрхийг хэлэх ба "Хяналт" хэмээх нэр үгийн утгаар хэрэглэж байгаа тохиолдолд дээр дурьдсан эрхийг эдлэх бололцоо олгож буй аливаа сонирхлыг хэлнэ. (**Хяналтад байх** гэдгийг мөн дээрхтэй холбогдуулан ойлгоно).

**ТУЗ-ийн гишүүн** гэдэг нь тус Компанийн дүрэм болон энэхүү Гэрээний 4.5 дугаар зүйлд заасны дагуу Компанийн ТУЗ-ийн гишүүний албан тушаалд томилогдсон буюу сонгогдсон хувь хүнийг хэлнэ.

**Захиран зарцуулах** гэж аливаа хөрөнгийн хувьд, түүнийг худалдах, шилжүүлэх, бусад хариуцуулах, барьцаалах, тухайн хөрөнгийг ирээдүйд борлуулснаас олох орлогыг хүлээн авагч болохоо зарлах, эсвэл бусад байдлаар тухайн хөрөнгийг (эсвэл тухайн хөрөнгө дэх сонирхлыг бүхэлд нь буюу хэсэгчлэн) захиран зарцуулахыг хэлнэ.

**Ногдол ашиг** гэж Компани татвар төлсний дараах үйл ажиллагааны ашгаас төлөхөөр ТУЗ шийдвэрлэсэн, аливаа мөнгөн болон мөнгөн бус хэлбэрээр олгож буй ашиг хуваарилалтыг хэлнэ.

**Санхүүгийн жил** гэдэг нь нэгдүгээр сарын 1-нээс арван хоёрдугаар сарын 31-нийг хүртэл хугацааг хэлнэ.

**Санхүүжүүлэх хугацаа** гэдэг нь Гэрээ бүрэн хүчин төгөлдөр болох өдрөөс эхлэн Хөрөнгө оруулалтын гэрээний 3.2.2-г зааснаар ил уурхайгаас бүтээгдэхүүн үйлдвэрлэж эхэлснээс хойш 3 жил өнгөрөх хугацааг хэлнэ.

**Засгийн газарт шилжүүлэх хувьцаа** гэж Гэрээ бүрэн хүчин төгөлдөр болох өдөр ТӨК-д шилжүүлэх, Компанийн нийт гаргасан 646,300 хувьцааны 34% буюу 219,742 хувьцааг хэлнэ.

**Хөрөнгө оруулалтын гэрээ** гэдэг нь Монгол Улсын Ашигт малтмалын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн дагуу Монгол Улсын Засгийн газар болон Компанийн хооронд тус Төсөлтэй холбогдуулан энэхүү Гэрээг байгуулах өдөр буюу ойролцоо өдөр байгуулсан хөрөнгө оруулалтын Гэрээг хэлнэ.

**Айвенхоу групп** гэж Канад Улсын Юкон мужид байгуулагдсан Айвенхоу Майнз Лимитед болон түүний хяналтад буй аливаа хуулийн этгээдийг хэлнэ.

**ЛИБОР** гэдэг нь хугацааны хувьд, тухайн хугацаанд АНУ-ын долларын ханшийг харуулах Ройтерийн дэлгэцийн ЛИБОР01 (буюу түүнийг солих Ройтерын дэлгэцийн өөр) хуудсан дээр санхүүжилт хийх хугацаанаас ажлын 2 өдрийн өмнөх өдрийн Лондонгийн цагаар 11

# Оюу Толгой Төслийн Хувь Нийлүүлэгчдийн Гэрээ

цагийн ханшны дунжийг ойлгоно. Энэхүү тоог 1/16-гаар буюу нэгж тоо хүртэл хувь болтол бүдүүвчилнэ. Хэрэв ийм дундаж байхгүй бол Айвенхоугийн санхүүжүүлэгчийн сонгож авсан, Лондонгийн банк хоорондын зах зээл дээр үйл ажиллагаа явуулдаг 3 томоохон банкны мэдэгдсэн, тухайн санхүүжилт хийх хугацаанаас ажлын 2 өдрийн өмнөх өдрийн Лондонгийн цагаар 11 цагийн ханшны дунжийг ойлгоно.

**Нэмэгдэл хүү** гэдэг нь энэхүү Гэрээний 8.6 дугаар зүйлд заасан (хүүгийн ханшны бүрэлдэхүүн хэсэг болох) зөрүүг хэлнэ.

**Үйл ажиллагааны зардал** гэдэг нь Төсөл болон Үндсэн үйл ажиллагаатай (үүнд хөрөнгийн зардал орохгүй) холбогдуулан Удирдлагын баг, Компани болон тэдгээрийн нэрийн өмнөөс гаргасан аливаа зардал болон төлбөрийг хэлнэ.

**Дийлэнх олонхи** гэж гуравны хоёр (2/3)-оос доошгүй хувь хэмжээг хэлнэ

**Гэрээний тал гэдэг нь** ТӨК, Айвенхоу, Компани болон тэдний энэхүү гэрээний дагуу хүлээсэн үүрэг, эдлэх эрхийг хууль ёсоор шилжүүлэн авсан этгээдийг хэлнэ.

**Эзэмшлийн хувь хэмжээ** гэдэг нь Компанийн нийт хувьцааны дотор Хувь нийлүүлэгчийн шууд эзэмшиж хувьцааны эзлэх хувийг хэлэх ба Засгийн газарт шилжүүлэх хувьцааг ТӨК-д шилжүүлсний дараа Хувь нийлүүлэгчдийн холбогдох хувь эзэмшил нь ТӨК-ийн хувьд 34%, Айвенхоугийн хувьд 66% тус тус байна.

**Компанийн өмчлөлийн мэдээлэл** гэдэг нь Хувь нийлүүлэгч болон түүний нэгдмэл сонирхолтой этгээд, Компани, Удирдлагын багийн Гуравдахь этгээдэд өгч буй нууц бөгөөд олон нийтэд гаргаагүй мэдээлэл, түүний дотор (гэхдээ үүгээр хязгаарлагдахгүйгээр) технологи, процесс, бүтээгдэхүүн, үзүүлэлт, шинэ бүтээл, арилжааны нууц, ноу-хау болон арилжааны хувьд эмзэг бусад мэдээллийг хэлнэ.

**Нэгдмэл сонирхолтой компани** гэдэг нь:

- а) Айвенхоу группийн гишүүний хувьд, Айвенхоу группийн бусад гишүүн болон Рио Тинто группийн аливаа гишүүн;
- б) Рио Тинто группийн гишүүний хувьд, Рио Тинто группийн бусад гишүүн болон Айвенхоу группийн аливаа гишүүн;
- в) ТӨК-ийн хувьд Төрийн өмч болон хяналтад бүрэн байдаг бусад аж ахуйн нэгж тус тус болно.

**Рио Тинто групп** гэж Их Британи Умард Ирландын Нэгдсэн Вант Улсад байгуулагдсан Рио Тинто Компани, Австрали Улсад байгуулагдсан Рио Тинто Лимитед компани болон тэдгээрийн хяналтад буй аливаа хуулийн этгээдийг хэлнэ.

**Хувьцаа** гэдэг нь Компанийн өөрийн хөрөнгийн энгийн хувьцааг хэлнэ.

**Хувь нийлүүлэгч** гэдэг нь ТӨК, Айвенхоу ба хувьцаа эзэмшиж байгаа бусад Талыг хэлнэ.

**Шилжүүлэгч** гэдэг нь энэхүү Гэрээний дагуу хувьцаагаа бүгдийг буюу нэг хэсгийг нь шилжүүлэхээр санал болгож буй Хувь нийлүүлэгчийг хэлэх ба тухайн хувьцааг шилжүүлсэн тухай бүртгэл хийгдэхээс өмнө болон хийгдсэний дараа тухайн Хувь нийлүүлэгчийг мөн Шилжүүлэгч гэнэ.

**Ажлын өдөр** гэдэг нь Монгол Улсын Улаанбаатар хотод, долоо хоногийн ажлын өдрийг хэлэх ба нийтийн баярын өдөр үл хамаарна.

# Оюу Толгой Төслийн Хувь Нийлүүлэгчдийн Гэрээ

Энэхүү гэрээнд заасан дараахь нэр томъёоны тодорхойлолтыг Хөрөнгө оруулалтын гэрээтэй мөн адил утгаар ойлгоно. Үүнд:

- Үйлдвэрлэлийн ажиллагаа эхлэх
- Үндсэн үйл ажиллагаа
- Оюу Толгой төсөл



# Оюу Толгой Төслийн Хувь Нийлүүлэгчдийн Гэрээ

**ҮҮНИЙГ ГЭРЧЛЭН ТАЛУУД** тус Гэрээг Улаанбаатар хотноо \_\_\_\_\_ - ний өдөр гарын үсэг зурж байгуулав.

**Эрдэнэс МГЛ Төрийн өмчит ХХК-ийг төлөөлж:**

\_\_\_\_\_

Гарын үсэг

\_\_\_\_\_

Нэр

\_\_\_\_\_

Огноо

**Британийн Виржинийн аралд бүртгэлтэй Айвенхоу Оюу Толгой Лимитед-ийг төлөөлж:**

\_\_\_\_\_

Гарын үсэг

\_\_\_\_\_

Нэр

\_\_\_\_\_

Огноо

**Айвенхоу Майнз Монголиа Инк ХХК-г төлөөлж:**

\_\_\_\_\_

Гарын үсэг

\_\_\_\_\_

Нэр

\_\_\_\_\_

Огноо

# Оюу Толгой Төслийн Хувь Нийлүүлэгчдийн Гэрээ